

InvesCore

“ИНВЕСКОР ББСБ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 09-р сарын 07-ны өдөр

№ 11/01

Улаанбаатар хот

Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 Компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.5.1 дэх заалт, 2022 оны 9 дүгээр сарын 07-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн нэмж гаргасан 4,016,363 ширхэг хувьцаагаар нийт гаргасан энгийн хувьцааны тоог нэмэгдүүлэн Компанийн Дүрэмд нийт гаргасан хувьцааны тоо 75,744,281 ширхэг байхаар өөрчлөлт оруулсугай.
2. Компанийн гаргасан хувьцааны тоонд өөрчлөлт оруулсан Компанийн Дүрмийг энэхүү шийдвэрийн Хавсралтаар баталсугай.
3. Энэхүү шийдвэрийн Хавсралтаар баталсан Компанийн Дүрмийг холбогдох хууль тогтоомжид заасан хугацаанд Санхүүгийн зохицуулах хороо, Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн бүртгэлийн хэлтэст зохих бүртгэлийг хийлгүүлэх ажлыг удирдан зохион байгуулах, шаардлагатай бусад арга хэмжээг авч ажиллахыг Гүйцэтгэх захирал /Д.Баясгалан/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Д. БАЯСГАЛАН

“ИНВЕСКОР ББСБ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 09-р сарын 07-ны өдөр

№ 11/05

Улаанбаатар хот

Компанийн хувьцаа хуваах төслийг батлах тухай
Компанийн тухай хуулийн 51 дүгээр зүйл, 62 дугаар зүйлийн 62.1.1, 62.1.3, 62.1.6 дахь заалт,
“Инвескор ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.5.1, 8.5.6 дахь
заалт, 2022 оны 9 дүгээр сарын 07-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын
Тооллогын комиссын дүнг үндэслэн **ШИЙДВЭРЛЭХ НЬ:**

1. Компанийн нэг бүр нь 227 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, нийт 82,000,000 ширхэг зарласан энгийн хувьцааны нэгж хувьцаа бүрийг 100 хувааж нэг бүр нь 2.27 төгрөгийн нэрлэсэн үнэтэй нийт 8,200,000,000 ширхэг зарласан энгийн хувьцаа болгон хуваасугай.
2. Компанийн нэг бүр нь 227 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, нийт 75,744,281 ширхэг гаргасан энгийн хувьцааны нэгж хувьцаа бүрийг 100 хувааж нэг бүр нь 2.27 төгрөгийн нэрлэсэн үнэтэй нийт 7,574,428,100 ширхэг гаргасан энгийн хувьцаа болгон хуваасугай.
3. Компани нь нэг бүр нь 2.27 төгрөгийн нэрлэсэн үнэтэй нийт 625,571,900 ширхэг зарласан боловч гаргаагүй хувьцаатай болохыг дурдсугай.
4. Компанийн хувьцааг хуваах зорилго, үндэслэл, хувьцаа хуваах ажлыг гүйцэтгэх журмыг тусгасан “Хувьцаа хуваах төсөл”-ийг шийдвэрийн Нэгдүгээр хавсралтаар баталсугай.
5. Компанийн хувьцаа хуваасантай холбоотой өөрчлөлтийг тусгасан Компанийн дүрмийн төслийг Хоёрдугаар хавсралтаар баталсугай.
6. Энэхүү шийдвэрийг хэрэгжүүлж, Үнэт цаасны бүртгэлийн журмын дагуу “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК, Санхүүгийн зохицуулах хороонд үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах тухай хүсэлт гаргах, бүртгүүлэх, зөвшөөрөл авах, зөвшөөрөл авсны үндсэн дээр Улсын бүртгэлийн байгууллагад холбогдох өөрчлөлтийг бүртгүүлэх болон зохих журмын дагуу мэдээллийг нийтийн хүртээл болгох зэрэг шаардлагатай арга хэмжээ авахыг Гүйцэтгэх захирал (Д.Баясгалан)-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Д. БАЯСГАЛАН

“ИНВЕСКОР ББСБ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 09-р сарын 07-ны өдөр

№А/ОС

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай

“Инвескор ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал нь Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дах хэсэг болон Тооллогын комиссын [ДУГААР] дугаар шийдвэрийг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүний бүрэн эрх дуусгавар болсонтой холбогдуулан дараах бүрэлдэхүүнийг 3 (гурван) жилийн хугацаатайгаар сонгосугай;

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн нэрс. Үүнд:

- 1) Баянмөнхийн Анхболд;
- 2) Далайжамцын Баясгалан;
- 3) Ралгаагын Пүрэв;
- 4) Гончигдоржийн Уянгахишиг;
- 5) Тунсагийн Тэлмэн;
- 6) Япон улсын иргэн Хирохито Намики;

Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдийн нэрс. Үүнд:

- 7) Чулуундоржийн Хашчулуун;
- 8) Дангаасүрэнгийн Энхбат;
- 9) Чимэдгочоогийн Өнөржаргал.

2. Компанийн тухай хууль, Компанийн Дүрэм, Засаглалын Кодекс болон бусад холбогдох хууль тогтоомжийн актуудыг мөрдөж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн нийт гишүүдэд үүрэг болгосугай;

3. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүний мэдээллийг холбогдох хууль тогтоомжид заасан хугацаанд Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлж, зохих зөвшөөрөл авах ажлыг Төлөөлөн удирдах зөвлөлийн Нарийн бичгийн даргад үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Д. БАЯСГАЛАН